



**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2017 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Журам батлах тухай

“Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дүрэм”-ийн 3.1, 5.4 дэх заалтууд, Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн “Магадлан итгэмжлэх комиссын үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллахыг Дээд боловсролын магадлан итгэмжлэлийн комисс, Мэргэжлийн боловсролын магадлан итгэмжлэлийн комисст үүрэг болгосугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.ЧУЛУУНБААТАР

Боловсролын магадлан
итгэмжлэх үндэсний зөвлөлийн
Удирдах зөвлөлийн 2017 оны 06
дугаар сарын 16-ны өдрийн ... тоот
тогтоолын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмаар БМИҮЗ-ийн Дээд боловсролын магадлан итгэмжлэх комисс, Мэргэжлийн боловсролын магадлан итгэмжлэх комисс /цаашид комисс гэх/ - ын үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Комиссыг байгууллага, хөтөлбөрийн болон урьдчилсан магадлан итгэмжлэлийн талаар шийдвэр гаргах зорилгоор байгуулна.

1.3. Комисс нь Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дүрэм болон энэхүү журамд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх хараат бус, хамтын, байнгын үйл ажиллагаатай бүтцийн нэгж байна.

1.4. Комиссын үйл ажиллагаатай холбоотой зардлыг БМИҮЗ-ийн төсвөөс санхүүжүүлнэ.

Хоёр. Комиссын бүрэлдэхүүн, түүний төлөөлөлийг сонгох

2.1. Комисс нь дарга, 12 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

2.2. Комиссын бүрэлдэхүүн нь дараах төлөөлөлтэй байна. Үүнд:

а. Төрийн өмчийн сургалтын байгууллагын төлөөлөл - 4

б. Төрийн бус өмчийн сургалтын байгууллагын төлөөлөл – 4

в. Ажил олгогч байгууллагын төлөөлөл – 2

г. Монголын их дээд сургуулиудын консерциум, Техникийн болон мэргэжлийн сургуулиудын холбооны төлөөлөл – 1

д. Оюутны байгууллагын төлөөлөл – 1 байна.

2.3. Комиссын гишүүнд нэр дэвшигч нь Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн шинжээчдэд тавих шаардлага шалгуурыг хангасан иргэн байна.

2.4. Комиссын гишүүнд дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, шинжлэх ухааны байгууллага, ажил олгогчид, мэргэжлийн холбоод, оюутны байгууллагаас нэр дэвшүүлнэ. Холбогдох байгууллагаас нэр дэвшүүлсэн иргэдийн материалыг БМИҮЗ-ийн Ажлын алба нэгтгэнэ.

2.5. Комиссын бүрэлдэхүүнийг БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн хуралдаанаар батламжилна.

2.6. Комиссын дарга сонгох эхний хуралдааныг БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн дарга /дэд дарга/ зарлан хуралдуулна.

2.7. Эхний хуралдаанаар комиссын гишүүдээс комиссын даргыг сонгоно.

2.8. Комиссын хуралдааны бэлтгэл ажлыг БМИҮЗ-ийн Ажлын алба зохион байгуулна.

2.9. Комиссын гишүүний бүрэн эрхийг дараах нөхцөлд хүчингүй болгоно. Үүнд:

2.9.1. чөлөөлөгдөх хүсэлт гаргасан;

2.9.2. 2-оос дээш удаа комиссын хуралдааныг шалтгаангүйгээр тасалсан;

2.9.3. нууцын гэрээ, холбогдох журмыг зөрчсөн;

2.9.4. бусад хүндэтгэх шалтгаан;

2.10. Комиссын бүрэлдэхүүнд гарсан сул орон тоог 1 сарын дотор энэхүү журмын хүрээнд нөхөн томилно.

Гурав. Комиссын бүрэн эрх

3.1. Комисс сургалтын байгууллагад ажиллах шинжээчийн багийн гишүүдийн тоо, төлөөллийг тогтооно.

3.2. Комисс сургалтын байгууллагын өөрийн үнэлгээний тайлан, БМИҮЗ-ийн томилсон шинжээчдийн дүгнэлтийг үндэслэн магадлан итгэмжлэх эсэх шийдвэр гаргана.

3.3. Маргаантай асуудал үүссэн тохиолдолд комисс сургалтын байгууллагын өөрийн үнэлгээний тайлан, шинжээчийн багийн тайлангийн төсөл, тайланд өгсөн сургалтын байгууллагын санал, БМИҮЗ-ийн Ажлын албанаас томилсон зохицуулагчийн гаргасан тодорхойлолт зэрэг баримт бичгийг нягтлан үзнэ.

3.4. Комисс үүссэн асуудлаар шийдвэр гаргахын тулд нэмэлт баримт, мэдээллийг Ажлын алба, шинжээчдээс шаардаж болно.

3.5. Комисс БМИҮЗ-д магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг сайжруулах чиглэлээр зөвлөмж хүргүүлж болно.

Дөрөв. Комиссын шийдвэр

4.1. Комисс нь дараах асуудлуудаар шийдвэр гаргах эрхтэй. Үүнд

4.1.1. Магадлан шинжлэх үеийг эхлүүлэх;

4.1.2. Магадлан шинжлэх үеийг дуусгавар болгох;

4.1.3. Сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх эсэх;

4.1.4. Сургалтын хөтөлбөрийг урьдчилсан магадлан итгэмжлэх эсэх шийдвэрийг батламжлах;

4.1.5. Сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх эсэх шийдвэрийг батламжлах;

4.2. Магадлан шинжлэх үеийг эхлүүлэх шийдвэрийг комиссын дарга, магадлан шинжлэх үеийг дуусгавар болгох шийдвэрийг комиссын хуралдаанаас тус тус гаргана.

4.3. Комиссын дарга магадлан шинжлэх үеийг эхлүүлэх шийдвэрийг гаргахдаа өөрийн үнэлгээний тайлангийн иж бүрэн байдал, БМИҮЗ-ийн Ажлын албанаас томилсон зохицуулагчийн тодорхойлолтыг үндэслэн шийдвэрлэнэ.

4.4. Сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх эсэх шийдвэрийг нээлттэй санал хураалтаар, олонхийн саналыг үндэслэн гаргана. Санал тэнцсэн тохиолдолд комиссын даргын саналаар шийдвэрлэнэ.

4.5. Сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх эсэх асуудлаар комисс дараах шийдвэрүүдийн аль нэгийг гаргана. Үүнд:

- 4.5.1. Магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагыг бүрэн хангаж байвал
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН
- 4.5.2. Магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагыг хэсэгчлэн хангаж байвал
НӨХЦӨЛТЭЙГЭЭР МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН
- 4.5.3. магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагыг хангахгүй байвал
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДЭЭГҮЙ

4.6. Сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх болон урьдчилсан магадлан итгэмжлэх тухай шийдвэрийг комиссын хуралдаанаар хэлэлцэн батламжилна.

4.7. Сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх эсэх комиссын шийдвэрийг БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн хуралдаанаар батламжилна.

Тав. Комиссын гишүүний эрх, үүрэг

5.1. Комиссын гишүүн дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- 5.1.1. Комиссын гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил байна. Холбогдох байгууллагын саналыг үндэслэн, бүрэн эрхийн хугацааг 1 удаа сунгаж болно.
- 5.1.2. Зохицуулагч болон шинжээчийн багаас нэмэлт мэдээлэл, тодруулга, тайлбар шаардах;
- 5.1.3. Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан санал хэлэх, асуулт асуух;
- 5.1.4. Зөвлөмж өгөх;

5.2. Комиссын гишүүн дараах үүрэгтэй. Үүнд:

- 5.2.1. Магадлан итгэмжлэлийн үйл явцыг зохицуулж буй хууль, дүрэм журамд захирагдах;
- 5.2.2. Комиссын бүх хуралдаанд оролцох;
- 5.2.3. Магадлан итгэмжлэлийн баримт бичигтэй танилцах, хэлэлцүүлэгт оролцох;
- 5.2.4. Комиссоос өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх;
- 5.2.5. Магадлан итгэмжлүүлж буй байгууллагын тухай нууцыг чанд хадгалах;

5.3. Дараах үндэслэлээр холбогдох үйл ажиллагаанаас нэрээ татна. Үүнд:

- 5.3.1. Тухайн сургалтын байгууллагатай ашиг сонирхолын зөрчилтэй бол;
- 5.3.2. Комиссын гишүүн болон гэр бүлийн гишүүн тухайн сургалтын байгууллагатай эдийн засгийн шууд харилцаатай бол;

Зургаа. Магадлан итгэмжлэх комиссын даргын эрх үүрэг.

6.1. Комиссын дарга нь дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 6.1.1. Комиссын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
- 6.1.2. Комиссын хуралдааны товыг тогтоох;
- 6.1.3. Хурал, хэлэлцүүлгийн үеэр комиссыг төлөөлөх;
- 6.1.4. Комиссыг төлөөлөн БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлд ажлаа тайлагнах;
- 6.1.5. Комиссын гишүүдэд зааварчилгаа өгөх, комиссын үйл ажиллагааны хүрээнд гишүүдийн ажил үүргийг хуваарилах;

- 6.1.6. Комиссын ажлын ач холбогдлыг нэмэгдүүлэх, гишүүдийг чадавжуулах зорилгоор зөвлөмж өгөх;
- 6.1.7. Магадлан итгэмжлэгдэх сургалтын байгууллагад ажиллах шинжээчдийн багийн гишүүдийн тоо, төлөөллийг тогтоох;
- 6.1.8. Өөрийн бүрэн эрхийг комиссын гишүүнд хэсэгчлэн болон бүрэн байдлаар тодорхой хугацаагаар шилжүүлэх;
- 6.1.9. Комиссын шийдвэр, хуралдааны тэмдэглэлд гарын үсэг зурах;
- 6.1.10. Бусад эрх үүрэг;

Долоо. Комиссын хуралдааны бэлтгэл хангах, зохион байгуулах

- 7.1. Хуралдаанаар дамжуулан комисс бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.
- 7.2. Комиссын хуралдааныг жилд 2 –оос доошгүй удаа зохион байгуулна. Хуралдааны товыг БМИҮЗ-ийн Ажлын албаны саналд үндэслэн, комиссын дарга тогтооно.
- 7.3. Гишүүдийн гуравны хоёроос дээш хувийн ирцтэй тохиолдолд хуралдааныг хүчин төгөлдөр гэж үзнэ. Ирц бүрдээгүй тохиолдолд хуралдааныг хойшлуулна.
- 7.4. Комиссын хуралдааныг комиссын дарга удирдана.
- 7.5. Комиссын гишүүдээс гадна хуралдаанд дараах хүмүүс оролцож болно. Үүнд:
 - 7.5.1. Шинжээчийн багийн гишүүд;
 - 7.5.2. БМИҮЗ-ийн Ажлын албанаас томилсон зохицуулагч;
 - 7.5.3. Магадлан итгэмжлэлд хамрагдаж буй сургалтын байгууллагын төлөөлөл;
 - 7.5.4. Мэргэжлийн зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга;
- 7.6. Комиссын хуралдаанаар шинжээчийн багийн ахлагч, хөндлөнгийн үнэлгээний үр дүн, дүгнэлтийг товч танилцуулна. Сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх тухай шийдвэрийг батламжлах асуудлыг хэлэлцэх үед БМИҮЗ-ийн дэргэдэх Мэргэжлийн зөвлөлийн дарга мэргэжлийн зөвлөлийн шийдвэрийг танилцуулна.
- 7.7. Хэлэлцэх асуудлаар сонсгол, хэлэлцүүлэг хийсний дараа комиссын гишүүд хаалттай хуралдаан хийж болно.

Найм. Комиссын хуралдааны тэмдэглэл

- 8.1. Хуралдааны тэмдэглэлийг бичгээр болон дуу хураагуур ашиглан тэмдэглэнэ. Тэмдэглэлийг БМИҮЗ-ийн Ажлын албаны мэргэжилтэн хөтөлнө.
- 8.2. Хуралдааны тэмдэглэлд дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:
 - 8.2.1. Хуралдаан зохион байгуулсан он, сар өдөр, газар, эхэлсэн, дууссан цаг
 - 8.2.2. Хуралдаанд оролцсон комиссын гишүүд болон бусад хүмүүсийн мэдээлэл
 - 8.2.3. Хэлэлцсэн асуудлууд
 - 8.2.4. Хуралдааныг нээж хэлсэн үг, асуулт, хариулт, тайлбар, хүсэлт, хэлэлцэх асуудлаар гарсан шийдвэр

8.2.5. Шинжээчдийн дүгнэлтийн талаарх тайлбар

8.2.6. Санал хураалтын дүн, хувь

8.3. Хуралдааны тэмдэглэлд комиссын дарга гарын үсэг зурж, баталгаажуулна.

8.4. Хуралдааны үеэр видео бичлэг хийж болно. Цахим болон цаасан мэдээллийг БМИҮЗ-ийн Ажлын алба архивлана.

Ес. Комиссын шийдвэртэй холбоотойгоор гомдол гаргах

9.1. Комиссын шийдвэр гарснаас хойш 1 сарын дотор багтаан тухайн сургалтын байгууллага БМИҮЗ-ээс баталсан журмын дагуу БМИҮЗ-ийн Өргөдлийн хороонд гомдол гаргаж болно.

9.2. БМИҮЗ-ийн Ажлын алба гомдлыг хүлээн авч, БМИҮЗ-ийн Өргөдлийн хороонд хүргүүлнэ. Гомдол гаргасан албан бичигт эрх бүхий этгээд гарын үсэг зураагүй, итгэмжлэх бичгийг хавсаргаагүй, гомдол гаргах хугацаанаас хэтэрсэн тохиолдолд ирүүлсэн гомдлыг буцаана.

9.3. Гаргасан гомдлыг Өргөдлийн хороо холбогдох журмын дагуу шийдвэрлэнэ.

Арав. Бусад

10.1. Энэхүү журамд БМИҮЗ-ийн Ажлын албаны санал, комиссын саналыг үндэслэн БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж нэмэлт өөрчлөлт оруулж болно.

10.2. Комиссын гишүүдийн урамшууллын хэмжээг БМИҮЗ-ийн Ажлын албаны захирлын тушаалаар тогтоож олгоно.

10.3. Комиссын гишүүдийн урамшууллыг жилд 2 удаа олгоно.